

З Ө В Л Ө М Ж

Зөвлөмж 1. Газар эзэмших, ашиглах, өмчлөхөөр иргэдээс гаргасан өргөдөл, хүсэлт, гомдлыг холбогдох хуульд заасны дагуу бүртгэж, хугацаанд нь шийдвэрлэх, холбогдох баримтуудад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр судалгаа, бүртгэлийг тухай бүр чанд хөтлүүлэх ажлыг хэвшүүлэх.

Сэргэлэн сумын газар зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлттэй танилцахад иргэн, аж ахуйн нэгжээс 2019 онд нийт 829 өргөдөл, хүсэлт ирүүлснээс 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 605 хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэж, 224 хүсэлтийн хугацаа хэтэрсэн, шийдвэрлээгүй байна. Шийдвэрлэх хугацаа нь хэтэрсэн өргөдөл, хүсэлт гаргасан иргэдтэй уулзаж, ярилцлага хийхэд газрын харилцаатай холбоотой үйлчилгээ хүнд суртал ихтэй, иргэдэд тэгш бус ханддаг, “сум, орон нутгийн иргэдээс гаргасан өргөдөл, хүсэлтийг жил дамнуулан шийдвэрлэж өгдөггүй, хотоос ирсэн иргэдийн хүсэлтийг өдөрт нь шийдвэрлэдэг” гэх зүйлийг хэлж байлаа. Тухайлбал, 2017 оноос хойш удаа дараа газар эзэмших хүсэлт гаргасан Н.Банзрагч тэргүүтэй 13 иргэний хүсэлтийг шийдвэрлээгүй бөгөөд 2019 онд иргэд сумын газрын даамал М.Аззаяад хандахад тэрээр “хүсэлтийг алга болгосон тул дахин гаргаж, кадастрын хэмжилт хийлгэ” гэсний дагуу иргэд дахин хүсэлтээ өгсөн боловч одоо болтол хүсэлтийг нь шийдвэрлээгүй байна.

Зөвлөмж 2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Засаг даргын өргөн мэдүүлсэн аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс хэтрүүлэн газар олголт хийсэн хууль бус үйлдлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хууль бус шийдвэрүүдийг хүчингүй болгох, үр дагаврыг арилгах чиглэлээр тодорхой арга хэмжээг авах.

Төв аймгийн Сэргэлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар хурлаар тус сумын 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн 10/08 дугаартай тогтоолоор баталжээ. Энэхүү төлөвлөгөөг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 07/106 дугаартай албан бичгээр хүргүүлсэн байна. Уг төлөвлөгөөг хянан үзэхэд дараахь нөхцөл байдал тогтоогдов.

Д/д	Баталсан төлөвлөгөөнд тусгагдсан байдал	Олгосон байдал	Хэтрүүлж олгосон хэмжээ
<i>Иргэнд зуслангийн зориулалтаар эзэмшүүлэх газрын төлөвлөлт хэсэгт</i>			
1.	1, 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт 9 байршилд 626 иргэнд 28,82 га газар	1, 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт 10 байршилд 679 иргэнд 46,43 га газар	1 байршилд 53 иргэнд 17.61 га газар
2.		Энхтайван хороололын хойд талд Манзушир явах зам дагуу 1 иргэнд, Зүүндэлгэрийн адагт 28 иргэнд, 1 байршил буюу Баруунзуун модны ам гэх газар 15 иргэнд	нийт 44 иргэнд шинээр

Сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй танилцахад төлөвлөгөөний 1.1-д ***Гэр хорооллын төлөвлөлт***, 1.1.4-д ***Иргэнд зуслангийн зориулалтаар эзэмшүүлэх газрын төлөвлөлт хэсэгт*** 1, 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт 10 байршилд 679 иргэнд 46,43 га газрыг эзэмшүүлэхээр баталсан байв.

Сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тухайн оны эхний улиралд багтаан аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт болон холбогдох газруудад хүргүүлдэг.

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хүргүүлсэн төлөвлөгөөтэй танилцахад төлөвлөгөөний 1.1-д **Гэр хорооллын төлөвлөлт**, 1.1.4-д **Иргэнд зуслангийн зориулалтаар эзэмшүүлэх газрын төлөвлөлт хэсэгт** 1, 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт **9** байршилд **626** иргэнд **28,82** га газрыг эзэмшүүлэхээр баталжээ.

Сумын 2019 оны газар зохион байгуулалтын хэрэгжиж буй төлөвлөгөө нь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн хувилбараас зөрүүтэй буюу Энхтайван хороололын хойд талд Манзушир явах зам дагуу 1 иргэнд, Зүүндэлгэрийн адагт 28 иргэнд, 1 байршил буюу Баруунзуун модны ам гэх газрыг нөхөн оруулж 15 иргэнд нийт 44 иргэнд шинээр газар эзэмшүүлэхээр нэмж, өөрчилсөн байна.

Дээрх байдлаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын холбогдох албан тушаалтнууд сумын Засаг даргын Тамгын газрын албан тушаалтнуудтай хамтран сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан төлөвлөгөөнд хууль бус **өөрчлөлт оруулсан** нь авлигын гэмт хэргийн шинжийг агуулж байна.

Зөвлөмж 3. Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх шийдвэр гаргахдаа бичиг баримтыг бүрдлийг хянах, хууль тогтоомжоор тавигдсан шаардлагыг хангуулах, баримт бичгийн судалгаа, бүртгэл, хөтлөлтийг эмх цэгцтэй болгох, нэгж талбар бүрийн хувийн хэргийг хөтөлж хэвшүүлэх, хувийн хэргийн мэдээллийг цахим системд оруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Сэргэлэн сумын Засаг даргаас 2019 онд нийт 687 захирамж гаргаснаас 493 буюу 71.7 хувь нь, 2020 онд гаргасан 59 захирамжийн 39 буюу 66 хувь нь газрын харилцаатай холбоотой шийдвэр байна. Эдгээр шийдвэрийг агуулга бүрээр хянан үзэхэд 2019 онд 372 буюу 75 хувь нь, 2020 онд 56.4 хувийг **газар эзэмших гэрчилгээг бусдад шилжүүлэхтэй** холбоотой шийдвэр эзэлж байв.

Шийдвэрийн агуулга		2019	2020
Сэргэлэн сум			
1	Газар өмчлүүлэх	33	1
2	Газар эзэмшүүлэх	51	12
3	Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх	372	22
4	Өмчилсөн газрын байршил өөрчлөх	21	2
5	Газар эзэмших эрхийн акт хүчингүй болгох	2	-
6	Газар эзэмшүүлэх зориулалт өөрчлөх	5	-
7	Газар өмчилсөн захирамжийн бүртгэлд залруулга оруулах	-	-
8	Эзэмшсэн газрын хэмжээнд өөрчлөлт орох тухай	5	-
9	Өмчилсөн газрын хаяг өөрчлөх	1	1
10	Газар эзэмшсэн захирамжийн бүртгэлд залруулга оруулах тухай	-	-
11	Газар ашиглуулах тухай	2	1
12	Газар эзэмших гэрчилгээ сунгах тухай	-	-
13	Хамтран эзэмшигч нэмэх тухай	-	-
14	Газар өмчлөх эрхийн актыг хүчингүй болгох	1	-
	Нийт	493	39

Сумын Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн А/489 дугаартай захирамжаар Х.Э-т 1-р баг 9-р зөрлөгт үйлдвэрлэлийн зориулалтаар олгосон 25 га газарт иргэд дураараа нас барагсдыг оршуулсан тул уг газрыг зориулалтын дагуу эзэмших боломжгүй тул байршлыг өөрчлүүлэх хүсэлт ирүүлснээр байршлыг сольж 1-р баг Таван

толгойн адагт үйлдвэрийн зориулалтаар 25 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна. Солигдсон 25 га газрын байршил нь Сэргэлэн сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газар байна. Сумын 2019 архивын баримтуудаас нягтлахад Сумын Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/439 дугаартай захирамжаар иргэн Х.Э-т 1-р багт 9-р зөрлөгт үйлдвэрлэлийн зориулалтаар 25 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр анх олгосон гэх нэгж талбарын хувийн хэрэг байхгүй байна.

Газар зэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхтэй холбоотой 372 шийдвэртэй холбогдох нэгж, талбарын хувийн хэргийн бүрдэл дутуу, эмх цэгцгүй, эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх бүртгэл, хөтлөлт, судалгаа гаргах ажил хангалтгүй байна. Тухайлбал, газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа тухайн этгээд нь уг эрхийн гэрчилгээг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа нотолгооны баримт, хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээний жагсаалт, эрхийн гэрчилгээ барьцаалсан тухай тэмдэглэл хөтлөлт зэрэгтэй танилцсан талаарх баримт байхгүй, бүртгэл хөтлөлтөд тавих хяналт сул байна. Үүний улмаас дээрх байдлыг ашиглан албан тушаалтан авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл өндөр байна. Иргэд газар эзэмших эрхээ шилжүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд сумын Засаг даргаас Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн бүрдэлд тавих хяналтыг бий болгох чиглэлээр нэгж талбар бүрийн хувийн хэргийн мэдээллийг цахим мэдээллийн санд оруулсан эсэхэд тогтмол хяналт тавьж хэвшүүлэх шаардлагатай.

Зөвлөмж 4. Сумын Засаг даргаас сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулахдаа тэдгээрээс гаргасан өргөдөл хүсэлт нь эрх бүхий байгууллагаас баталсан загвар маягтын дагуу эсэх, өргөдөл, гомдол хүсэлт гаргасан огноо, түүнийг бүртгэсэн хугацаа, хүсэлт гаргасан газрын хэмжээ зэрэгт тавих бүртгэл хяналтыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч, хэрэгжүүлэх.

2019 онд тус сумын хэмжээнд хуулийн этгээдэд 19 байршилд 44 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх Засаг даргын захирамж гарсан байна. Захирамж бүрээр тулгалт хийж нягтлан үзэхэд:

1. Сумын Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/80 дугаартай захирамжаар 6076475 регистрийн дугаартай “Мон фалү консалтинг” ХХК-д 4 дүгээр баг Бүрдэн дугуйн энгэр гэх газарт үйлдвэрлэлийн зориулалтаар 2 га газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

⇒ Уг байршлын газар нь сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 2.1.1-д заасан иргэн, ААН-д эзэмшүүлэх газрын байршил хэмжээ хэсгийн 1-д 1 дүгээр баг Бүрдэн дугуйн энгэрт 2 га үйлчилгээ Дуудлага худалдаагаар гэсэн хэсэгт бүртгэгдсэн байна.

⇒ Сумын 2019 оны архивын баримтуудаас Сумын Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/80 дугаартай захирамжаар 6076475 регистрийн дугаартай “Мон фалү консалтинг” ХХК-д үйлдвэрлэлийн зориулалтаар олгогдсон 2 га газрын хувийн хэргийг гаргуулан авахаар хандахад хувийн хэрэг байхгүй байна.

⇒ Энэ нь Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан загварын дагуу гаргана” гэж заасныг болон мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т “Энэ хуулийн 32.2, 32.3-т заасан баримт бичгийг хавсаргасан хүсэлтийг хүлээн авмагцаа сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журмын дагуу бүртгэнэ. Бүртгэлд хүсэлтийг хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутаар тэмдэглэх бөгөөд энэ тухай тодорхойлолтыг хүсэлт гаргасан этгээдэд гаргаж өгнө.”, 33 дугаар зүйлийн 33.1-д “Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг

дараахь журмыг баримтлан шийдвэрлэнэ:(33.1.2-энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно”) гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Сумын Засаг даргаас 2019 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн А/489 дугаартай захирамжаар иргэн Х.Э-т 1-р багт 9-р зөрлөгт үйлдвэрлэлийн зориулалтаар олгосон 25 га газарт “иргэд дураараа нас барагсдыг оршуулсан тул уг газрыг зориулалтын дагуу эзэмших боломжгүй тул байршлыг өөрчлүүлэх хүсэлт” ирүүлсний дагуу байршлыг сольж 1-р багт Таван толгойн адагт үйлдвэрийн зориулалтаар 25 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэжээ. Ийнхүү өөрчилсөн 25 га газрын байршил нь Сэргэлэн сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаагийн зэрэгцээ тухайн газрын нэгж талбарын хувийн хэрэг байгууллагын архивт байхгүй.

Зөвлөмж 5. Сумын Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт олголт хийхгүй байх, төлөвлөгөөнд тусгаагүй газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулахаар шийдвэрлэсэн холбогдох шийдвэрүүдийг хүчингүй болгох арга хэмжээ авах, уг шийдвэрийг сумын цахим хуудас, мэдээллийн самбараар ил тод, нээлттэй болгож, иргэд олон нийтийг мэдээллээр хангах.

Төв аймгийн Сэргэлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/24 дугаартай 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн, 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах тухай тогтоолын 4 дэх хэсэгт “2018 оны төлөвлөгөөнд тусгаагүй газарт олголт хийхгүй байх, орон нутгийнхаа үндсэн иргэдэд 0,2 га-р газар өмчлүүлэх, 0,07 га-р эзэмшүүлэх ажлыг нэн тэргүүнд тавих, мэдээлэл сурталчилгаагаар хангах, хуулийн дагуу эзэмшил авсан газар дээрээ үйл ажиллагаагаа явуулаагүй газрын төлбөрөө төлөөгүй иргэд, аж ахуйн нэгжийн газрыг хурааж дахин эдийн засгийн эргэлтэд оруулж ажиллахыг Засаг дарга /Э.Энхбаяр/-т үүрэг болгосон байтал Засаг дарга Э.Энхбаяр нь 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах газруудыг аж ахуйн нэгж, компаниудад албан тушаалын байдлаа ашиглаж дур мэдэн олгон, бусдад давуу байдал бий болгосон байна.

№	Захирам-жийн дугаар, огноо	Байршил, Олгосон аж ахуйн нэгж	Газрын Хэмжээ /га/	Зориулалт, Хугацаа	Хэлбэр	Хариуцах эзэн
1	18/04/10 A/87	4-р баг Бараат уулын энгэрт “Нэг л сайхан” ХХК	50	Буяны цэцэрлэгт хүрээлэн 15 жил	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Аззаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
2	18/06/20 A/238	4-р баг Тахилтын энгэрт “Госок күмпэн монголиа” ХХК	30	Шашины 15 жил	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Аззаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
3	18/08/31 A/322	Оногийн Батбилэгт /РД:НС82071772/ Зүрхний энгэр 2-р гудамж 205 тоот 4,000,000 сая үнэ бүхий	0,5	Гэр бүлийн	Үнэгүй өмчлүүлсэн	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Аззаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн

4	18/09/03 A/324	Сүхбаатар Эрдэнэбаатар /РД:УШ96061452/ Бараат уулын баруун талд	3	Үйлчилгээ- ний 15 жил	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
5	18/10/01 A/401	Баатарчулуун Гүндсамбуу /РД:ГЮ86100913/ 61-ийн гарам	0,5	Гэр бүлийн	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
6	18/10/01 A/401	Мөнхбат Ариунболд /РД:НЮ86101815/ 61-ийн гарам	0,5	Гэр бүлийн	Шууд олгоосн	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
7	18/10/01 A/401	Алтангэрэл Жавзанчойжий /РД:ЧМ77100171/ 61-ийн гарам	0,5	Гэр бүлийн	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
8	18/10/01 A/401	Баасанжав Нямсүрэн /РД:ЕЮ90030515/ 61-ийн гарам	0,5	Гэр бүлийн	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
10	18/10/05 A/419	1-р баг 9-р зөрлөг Оюу констракшн ХХК	6.7	Үйлдвэрийн 15 жил	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
11	18/10/22 4/439	4-р баг Оорцогийн баруун талд засмал замын зүүн талд	10	Үйлчилгээ- ний 15 жил	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
12	18/08/30 A/321	4-р баг Марал 3-р гудамж 304 тоот Өлзийхүү Эрдэнэбаяр /РД:УУ13212900/	0,2007	Гэр бүлийн	Үнэгүй өмчлүүл -сэн	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
13	18/08/30 A/321	4-р баг Марал 4-р гудамж 409 тоот Эрдэнэбат Амартүвшин /РД:ЦК09231018/	0,1793	Гэр бүлийн	Үнэгүй өмчлүүл -сэн	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
14	18/08/30 A/321	4-р баг Марал 4-р гудамж 407 тоот Оюун-Эрдэнэ Цогзолмаа /РД:НС03303000/	0,1798	Гэр бүлийн	Үнэгүй өмчлүүл -сэн	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
15	18/08/30 A/321	4-р баг Марал 3-р гудамж 407 тоот Рэнцэн Оюун-Эрдэнэ /РД:ЦК07292711/	0,2722	Гэр бүлийн	Үнэгүй өмчлүүл -сэн	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
16	18/09/25 A/385	4-р зөрлөг Энхтайван Батзаяа /РД:УП91041312/	0,49	Зуслан 15 жил	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн

17	19/02/27 A/80	4-р баг Бүрдэн дугуйн энгэрт “Мон фалу консалтинг” ХХК	2	Үйлдвэр, үйлчилгээ 15 жил	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн
18	19/02/27 A/81	4-р баг Бүрдэн дугуйн ард “Мон фалу консалтинг” ХХК	2	Үйлдвэр, үйлчилгээ 15 жил	Шууд олгосон	Засаг дарга Э.Энхбаяр, Газрын даамал М.Азаяа, Байгаль орчны байцаагч Ц.Цэвэлсүрэн

Дээрхээс үзэхэд ийнхүү нийт **103.7** га газрыг үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар, **3.822** га газрын гэр бүлийн зориулалтаар хууль бусаар олгосон нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх” хориглолтыг зөрчиж байна.

Тухайлбал, дээрх жагсаалтын 17, 18-д бичигдсэн 4-р баг Бүрдэн дугуйн энгэр 2 га, дахин 2 га нийт 4 га газрыг “Мон фалу консалтинг” ХХК-д олгох захирамж гаргахдаа Засаг дарга Э.Энхбаяр өөрөө захирамжаа боловсруулсан байна.

Газар олголт хийсэн хувийн хэргүүдээс түүвэрлэн танилцахад 2019 оны А/179 дугаар захирамжаар газар олгогдсон А.Баяржаргал, Д.Баясгалан, П.Оргилболд, А/186 дугаар захирамжаар газар олгогдсон иргэн Б.Лхагвацэнд нарын газар хүссэн өргөдөл байхгүй, хүсэлт хүлээн авсан бүртгэлд ороогүй байгаа нь Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т “Энэ хуулийн 32.2, 32.3-т заасан баримт бичгийг хавсаргасан хүсэлтийг хүлээн авмагцаа сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журмын дагуу бүртгэнэ. Бүртгэлд хүсэлтийг хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутаар тэмдэглэх бөгөөд энэ тухай тодорхойлолтыг хүсэлт гаргасан этгээдэд гаргаж өгнө.” гэснийг зөрчсөн байна.

Зөвлөмж 6. Дуудлага худалдаа явуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг газрын тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, дуудлага худалдааны зарыг мэдээллийн самбар бусад боломжит хэлбэрээр олон нийтэд хүргэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр тэгш хангах нөхцөлийг бүрдүүлэх

Төв аймгийн Сэргэлэн суманд тухайн онд 48 газрыг дуудлага худалдаанд оруулж зохион байгуулахаар нээлттэй дуудлага худалдааг цахимар буюу “Газрын цахим бирж”-ээр зарласан байх бөгөөд үүний зөвхөн 14 газрын дуудлага худалдаанд иргэд оролцсон, 34 газрын дуудлага худалдаанд оролцогч оролцоогүй байна.

Дээрх дуудлага худалдаанд интернэт орчин бүхий газраас хэн ч оролцох боломжтой бөгөөд дуудлага худалдааны зарыг зөвхөн цахим хуудсаар зарлаж “оролцогчгүй” гэх шалтгаанаар “дуудлага худалдаа”-г хүчингүй болгож байна.

Зөвлөмж 7. Засаг даргын Тамгын газар болон иргэдийн Төлөөлөгчдийн хурал Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-дэх “ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах”, 12.1.2-дахь “харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох”, 12.1.3-дахь “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих” заалтыг хэрэгжүүлэх талаар идэвх санаачилгатай ажиллах, түгээмэл тархацтай газар олголтын мэдээлэл, ялангуяа хэдэн аж ахуйн нэгж, ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгох.

Нөхцөл байдлыг дүгнэхэд тус суманд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдэд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлээгүй, тэдгээрээс тухайн жилд ажилласан эсэх талаарх үйл ажиллагааны тайлан авах ажлыг хэвшүүлээгүй зэрэг нь Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах”, 12.1.2-д “харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох”, 12.1.3-д “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих”-аар заасныг хэрэгжүүлээгүй гэж дүгнэх үндэслэл болж байна.

Авлигатай тэмцэх газар